



“ШИВЭЭ-ОВОО”

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэрийн гудамж, 9 дүгээр байр, “А1” тоот хуралдав.

Хурлын дарга: Н.Жавзанпагма

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан шийдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Хуралд оролцсон:

Компанийн төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж хурлын дарга Н.Жавзанпагма Эрдэнэс Монгол ХХК-ийн Нэгдлийн хяналтын асуудал хариуцсан менежер, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян /саналын эрхтэй/, Түлш, эрчим хүчний группийн менежер Н.Пүрэвдорж, Гэрээ, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн О.Тэлмүүн нар оролцов.

Хуралд оролцсон бусад:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нямдэлгэр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Солонго нар оролцлоо.

Хурлаар хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Шийдвэрлэсэн нь:

Тооллогын комиссын дарга Э.Мандахнаран:

Тооллогын комисс дараах хурлын ирцийг бүртгэн дүгнэж бүртгэж байна. Шивээ Овоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13.419.101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1.561 хувьцаа эзэмшигч байдаг үүнээс Төрийн өмчийг төлөөлж хэрэгжүүлэх Эрдэс Монгол ХХК 90% 12.077.191 хувьцаатай ирсэн байна. Бусад 32 хувьцаа эзэмшигч ирсэн. Нийт ирсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо 12.078.235 ширхэг байна. Ирцийн хувьд 90,0077 хувьтай байна. Компанийн тухай хуулийн 69.1-д зааснаар Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал

хүчин төгөлдөр болдог. Нийт хувьцаа эзэмшигчдийн 90 хувь ирсэн, 10 хувийн 77% ирсэн учраас хурлын ирц бүрдсэн гэдгийг хурлын даргад танилцуулж байна. Баярлалаа.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын эрчим хүчний салбарын үндсэн түүхий эдээр хангадаг, стратегийн ач холбогдол бүхий Шивээ Овоо ХК-ийн маань энэ 2025 орны ХЭХ өнөөдөр ингээд эхэлж байна. ХЭХ-ын ирцийн мэдээллийг Тооллогын комиссын дарга Мандахнаран ТУЗ-өөс байгуулагдсан комиссын дарга нар сая Мандахнаран та бүхэнд ирцийн мэдээллийг хүргэлээ. Шивээ Овоо ХК-ийн 90%-ийн хувийг Монгол Улсын ЗГ эзэмшдэг. Үүнийг төлөөлж Эрдэнэс Монгол ХХК. Та бүхэнд Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирлын тушаалыг танилцуулъя. Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаал ХЭХ-д оролцуулах тухай Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, Эрдэнэс Монгол ХХК-ийн Компанийн дүрмийн 3.3.6, 3.5.4 Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 2.1.1-д заасныг тус тус үндэслэн тушаах нь.

1. Шивээ-Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд Эрдэнэс Монгол компанийн Нэгдлийн хяналтын асуудал хариуцсан менежер Жавзанпагма миний бие, Геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Төгсбуян /саналын эрхтэй/, Түлш эрчим хүчний группийн менежер Пүрэвдорж, Гэрээ эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Тэлмүүн нарыг томилон оролцуулсугай.
2. Шивээ-Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг зохих журмын дагуу даргалахыг Н.Жавзанпагмад даалгасугай.
3. Шивээ-Овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралд баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.
4. ХЭХ-д оролцсон талаарх тайланг 2025 оны 5 дугаар сард багтаан тайлагнахыг Н.Жавзанпагмад үүрэг болгосугай. Гүйцэтгэх захирал Наранцогт.

Та бүхэндээ өнөөдрийн ХЭХ-аараа хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулъя. Шивээ-Овоо ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 25/06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар өнөөдрийн ХЭХ-аар хэлэлцэх асуудлыг баталсан байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлнэ. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батална
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батална.
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан шийдвэрийг ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга
4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
5. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай гэсэн 6 асуудлыг хэлэлцэнэ.

Хурал эхлэхээс өмнө хуралдааныхаа дэгийг танилцуулаад нягтлаад авъя. Хурал даргалагч Хурлын үйл ажиллагааг нээж, хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулна, хэлэлцэх асуудлын дарааллын дагуу танилцуулж бүх асуудлуудаа хэлэлцэх асуудлынхаа дарааллын дагуу танилцуулж хэлэлцэнэ. Энэ нь тус бүр 30 минут, хуралд оролцогчдоос асуулт хариулт явна. Хүн бүр асуултыг 1 3 минутад багтаагаад асуултаа асуух нь байна. Хуралд оролцогчдын санал дүгнэлт хүн тус бүр 3 минут, завсарлага 20 минут, тооллогын комисс тогтоолоо танилцуулна 5 минут, хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж батлуулах асуудал тус бүрээр 15 минут, хурлын үйл ажиллагааг хаах 5 минут, хуралдааны дэгийг ТУЗ-өөс ингэж баталж өгсөн байна. Та бүхэн хуралдааныхаа дэгийг хүлээн зөвшөөрч байна уу?

Хувьцаа эзэмшигчид:

Зөвшөөрч байна.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Энхтүвшин захирал танилцуулна.

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн амгаланг айлтгая. Танилцуулгаа эхлэхээс өмнө компанийнхаа ХЭХ-ыг хүндэтгэж хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Би та бүхэндээ Шивээ-Овоо ХК-ийн гүйцэтгэх захирлын хувьд 2024 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулъя. Дэлгэрэнгүй тайлан бол та бүхэнд тараагдсан материал байгаа. Шивээ-Овоогийн уурхай өнөөдрийн байдлаар жилд 2 сая тонн орчим нүүрсийг олборлож төвийн эрчим хүчний системд нийлүүлэх техникийн болон хүн хүчний хүчин чадал зохион байгуулалттай ажиллаж байгаа уурхай байгаа. Улаанбаатар хотоос 260 орчим километр Говьсүмбэр аймгийн нутагт оршдог. Бид төвийн эрчим хүчний систем тэр дундаа төвийн эрчим хүч дулааны хамгийн гол үйлдвэрлэгч 4 дүгээр цахилгаан станцын нүүрсний хэрэглээний бараг 50%-ийг, мөн Улаанбаатар хотод оршдог томоохон дулааны станц болох Амгалангийн дулааны станцын нүүрсний хэрэглээний мөн 50%-ийг ханган нийлүүлдэг. Стратегийн ордод ЗГ, Их хурлын шийдвэрээр ингэж хамрагдсан. Ийм ач холбогдолтой уурхай байгаа. Нийт компани ХК болон зохион байгуулагдсан. Нийт хувьцааны 90% Монгол Улсын ЗГ буюу Эрдэнэс Монгол компани эзэмшдэг. 10%-ийг бусад иргэд хувьцаа эзэмшдэг. Бид Эрдэнэс Монгол компанийн ашиглалтад байдаг лицензийг нь эзэмшдэг. Шинэ усны хэсгийн 4290 га талбайд нүүрс, эрчим хүчний нүүрс, хүрэн нүүрс олгуулах ийм үйл ажиллагаа явуулдаг. Нүүрсний нөөцийн тухайд миний танилцуулга дээр дараа нь нэлээн тодорхой гарна. Одоогийн байдлаар 594, 600 сая орчим тонн нүүрсний нөөцтэй. Өнөөдрийн хүчин чадлаар цаашид үргэлжилнэ гэвэл бараг 200-аад жил ашиглах юм. Шивээ-Овоогийн уурхай өнөөдөр хүчин чадлаар төсөөлөх юм бол 200-аад жил ашиглах ийм боломжтой нөөцтэй гэж ойлгож болно. 1990 онд байгуулагдсан. Монголчууд өөрсдөө байгуулсан ийм онцлогтой уурхай байгаа. 1995 онд ХК болон зохион байгуулагдсан. Өнөөдрийн хувьцаа эзэмшигч та бүхэн энэ он цагаас эхлээд хувьцаа эзэмшигч хөрөнгийн эзэн болох ийм эхлэл зураг тавигдсан түүхтэй. ЗГ-ын тогтоолоор Эрдэнэс Монгол компанийн охин компани болж 2023 оноос хамрагдаж зохион байгуулагдсан. 2024 онд үйлдвэрлэл, уурхайн үндсэн үйлдвэрлэл, олборлолт, нүүрс олборлолт, нийлүүлэлтийн энэ үзүүлэлтүүдийг 110 хүртэл хувиар давуулан биелүүлээд ажиллаж байгаа. Уурхай байгуулагдсанаас хойш 35 жилийн түүхэнд хамгийн өндөр хэмжээтэй буюу 2 сая 630 мянган тонн нүүрсийг олборлож төвийн эрчим хүчний систем ДЦС-уудыг нийлүүлсэн. 2024 оны бүтэц зохион байгуулалтын хувьд ТУЗ, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, 5 хэлтэс, 7 хэсэг гэсэн ийм бүтэцтэй, батлагдсан 487 орон тоотой. Хувьцаа эзэмшигчдийн тухайд бол нийтдээ 13,419,101 ширхэг ийм үнэт цаас хувьцаа хөрөнгийн бирж дээр гаргаж арилжаалагдсан. Үүнээс 1548 орчим хувьцаа эзэмшигчид энэ үнэт цаасыг эзэмшдэг. 2024 оны уулын ажлын компанийн биелэлтийг та бүхэнд товч байдлаар танилцуулъя. Бид 2 сая 400 мянган тонн нүүрс олборлож 2 сая 380 мянган тонныг борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. Гүйцэтгэлээр 2 сая 633 аравны 3 мянган тонныг олборлож 2 сая 623 аравны 6 мянгыг нийлүүлсэн. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн ийм амжилттай ажилласан. Уурхайн өнөөгийн хүчин чадал бол дөнгөж 2 сая тонныг л олборлох хүчин чадалтай яваа. Бодит байдал дээр бид төвийн эрчим хүч дулааныг хангахын тулд станцуудын шаардлагаар 2 сая 630 буюу хүчин чадлаасаа давсан ийм хэмжээгээр нүүрсийг олборлож нийлүүлээд ажиллаж байгаа. Уурхайн ерөнхий үйл ажиллагааг харуулсан тойм зургийг бас та бүхэн танилцуулга дээрээс харж байгаа. Уурхайн олборлолтын хувьд бол тээвэргүй буюу цахилгаан экскаваторыг ашигладаг тээвэр буюу автомашинаар хөрс суулгалтын ажлыг гүйцэтгэдэг гэсэн хосолсон системээр үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой байгаа. Уурхайн бүртгэлд бол одоо 40 техник ашигладаг. Мэдээж бид сүүлийн жилүүдэд техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтүүдийг нэлээдгүй хэмжээгээр хийж байгаа ч

гэсэн бүх техник тоног төхөөрөмжөө бүрэн шинэчилж амжаагүй байгаа. Зарим техник тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх хугацаа нь дууссан, актлах зайлшгүй шаардлагатай байгаа. Гэхдээ өнөөдрийнхөө нөхцөлд ямар ч байсан бид техникийн бэлэн байдлын коэффициентийг 76%-тай техник ашиглалтынхаа хувьд коэффициентийг 71%-тай ашиглаж өмнөө тавьсан зорилт төлөвлөгөөгөө биелүүлээд ажиллаж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье. 2024 оны тухайд бид техник тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хөрөнгө оруулалтаар нэлээн хийж хий хэрэгжүүлсэн байгаа. Бид технологийн автомашин 4 ширхгийг шинээр худалдаж авсан. Гидерэкско бид 3-ыг худалдаж авсан, ачигч 4 ширхгийг шинээр худалдаж авсан. Бусад түлш тээврийн машин уурхайн дотоод зориулалтын автомашин зэрэг зүйлүүдийг авсан. Төлөвлөгөөгөөр бид 37,6 тэрбумын хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 25,6 тэрбумыг хийж хэрэгжүүлсэн. Мэдээж хэрэг хамгийн гол зүйл бол компанийн орлого санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалж энэ төлөвлөсөн хэмжээндээ хүрэх бөгөөд техникийн шинэчлэлтийг өөрсдийнхөө боломжид тулгуурлаж 25,6 тэрбумаар хийж гүйцэтгэсэн. Ингэхдээ мэдээж компанийн мөнгө санхүүтэй холбоотой. Бид шууд мөнгийг нь төлж техникийн шинэчлэлтүүдийг өндөр үнэтэй уул уурхайн зориулалтын техникүүдийг худалдаж авах ийм боломж бололцоо байхгүй учраас банкны баталгаагаар, өөрөөр хэлбэл зээлээр лизингээр худалдаж авч байгаа. Өнгөрсөн 2024 онд 19,7 тэрбум мянган төгрөг санхүүжүүлсэн худалдаж авсан техник тоног төхөөрөмжөө үлдсэн 5,9 тэрбумыг бид 2025 онд төлж барагдуулахаар ажиллаж байгаа. Сар бүр графиктайгаар төлбөрөө төлөөд явж байгаа. Хөрөнгө оруулалтын ерөнхий товч байдлаар ингээд танилцуулахад 2023 онд жишээлбэл ердөө 4,6 тэрбумыг хөрөнгө оруулалт техникийн шимтгэлд нь төлөөд 2,9 тэрбумыг л хэрэгжүүлнэ гэж байсан 2,9 тэрбум 2024 онд та бүхэнд тайлан тавьж байгаа дөнгөж сая дууссан 2024 оны тухайд 37,6 тэрбумыг төлөвлөөд 25,6 тэрбумын хөрөнгө оруулалтыг ингээд шинэчилж хийсэн. Энэ бол нэлээн өндөр хэмжээнд хийгдсэн дүн байгаа. Сүүлийн жилүүдэд ер нь ингэж хийгдээгүй. 2025 оны тухайд бас би та бүхэндээ танилцуулж байна. Нэгэнт хувьцаа эзэмшигч дээрээ цугласан нь дээр бид 37,8-ыг тэрбумын техникийн шинэчлэлтийг хөрөнгө оруулалтыг төлөвлөж байгаа гэхдээ энэ бол бид нарын бас боломж бололцоо маань бас нэлээн хязгаарлагдмал байгаа. Энд бол 13,5 тэрбумыг л 2025 ондоо санхүүжүүлнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Хөрөнгө оруулалтын сүүлийн 8 жилийнхийг та бүхнээс ингээд нэгтгээд танилцуулчихъя гэж бодож байна. Сүүлийн 8 жилд бол нийтдээ 79,6 тэрбум хөрөнгө оруулалт хэрэгжүүлээд байгаа юм. Энэ нь сүүлийн хориод жил хийгдээгүй том хөрөнгө оруулалт байгаа гэдгийг та бүхэнд бас танилцуулъя.

2024 оны санхүү эдийн засгийн үзүүлэлтийг товч байдлаар танилцуулъя. 2024 оны гүйцэтгэлээр 2,6 сая тонн нүүрс олборлоод 2 сая 623,5 мянган тонн нүүрсийг худалдан борлуулсан цахилгаан станцуудад. Ингээд 112,2 тэрбумын орлого олж, зардал нь 126,5 тэрбумын зардал гараад жилийн эцсийн тайлан дүнгээрээ бид 14,2 тэрбумын алдагдалтай өнгөрсөн жил ажилласан. 2024 оны төлөвлөгөөгөөр бол 18,1 тэрбумын алдагдалтай ажиллахаар ийм төлөвлөгөө гарсан. Ийм төлөвлөгөө батлуулаад ажилласан. Ингээд бүх алдагдал маань бага хэмжээгээр 4 тэрбум орчмоор буураад 14,2 тэрбумын алдагдалтай ажилласан байгаа. Яагаад алдагдалтай ажилласан бэ гэдгийг одоо та бүхэнд үндэслээд тодруулъя. Бидний тухайд бол эрчим хүчний тухай хуулиараа эрчим хүчний зохицуулах хороо гэдэг байгууллага нүүрсний үнийг тогтоодог. Нүүрсний үнэ бол тэдний баталсан тогтоолоор хатуу зохицуулалттай. Тэр тогтоолоор бол 38,990 төгрөгөөр нүүрсийг худалдан олгож байсан. 2024 оны 12 сард он дуусахын өмнө эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор эко нүүрсний үнийг өртөгт нь хүргэж нэмэгдүүлэх ийм шийдвэр гаргаад 53,197 төгрөгөөр тогтоосон байгаа юм. Энэ хүртэлх хугацаанд буюу энэнээс өмнө тогтоож байсан 38,990 төгрөгөөр тогтоож байсан үнэ компанийг алдагдалд оруулж байсан. Ийм үнэ байсан юм. Энэ ямар учиртай билээ гэхээр 2024 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр үзэхэд нэг тонн нүүрсийг 48,046 төгрөгөөр үндсэндээ вагоны тэвш дээр ачаад явуулж байгаа юм. Энэ бол нүүрсний бодит өртөг. Ийм зардлаар л ийм үнээр, ийм мөнгөөр бид нар 1 тонн нүүрсийг вагоны нуруун дээр авчирч өгч байгаа юм. Зарахдаа 38,990

буюу энэнээсээ даруй 9 мянган төгрөгөөр бага хувиар зарчихна. Ийм тогтолцоотой явж байсан. Монгол Улсын ЗГ-ын шийдвэрээр ер нь бол энэ нүүрсний үнийг ингэж олон жил алдагдалтай цахилгаан дулааны үнийг олон жил алдагдалтай явуулсан учраас алдагдалгүй хэмжээнд нь аваачихын тулд үйлдвэрлэж байгаа өртөгт нь ойртуулъя гэдэг ийм шийдвэр гарсан. Энийг бас та бүхэн мэдэж байгаа байх мэдээлэл улс тээвэрт хүрсэн. Та бүхний ч гэсэн одоо хэрэглэж байгаа цахилгаан дулааны үнэ бол дулааны үнэ бол нэмэгдээгүй цахилгааны үнэ бол тодорхой хэмжээгээр нэмэгдсэн энэ нэмэгдэл бол зарим нэг хэсэг нь манай уурхай дээр бас нэмэгдэж байгаа гэдгийг бас ойлгох хэрэгтэй. Энэ нэмэгдлээр бид яасан бэ гэхээр зэрэг 53,197 буюу ер нь бол бараг компани байгуулагдсан цагаасаа хойш анх удаагаа нүүрсээ алдагдалгүй зарах ийм боломжит үнийг тогтоож өгсөн юм. Хүмүүс ойлгох одоо нүүрсний үнийг чөлөөлсөн гэж яриад байгаа юм. Цахилгааны үнэ чөлөөлсөн үгүй л дээ чөлөөлөөгүй. Ерөөсөө л тэрийг үйлдвэрлэхийн тулд гарч байгаа зардалд нь алдагдалгүй байх яг тэр хэмжээнд нь л үнийг нь аваачсан юм. Тэр үнэ бол 53,197 төгрөг байсан. Энэ үнийг бид 2024 оны 12 сарын 6-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн учраас энэнээс хойш мөрдөж явж байгаа. Одоо өөрөөр хэлбэл 2025 онд бид энэ үнийг мөрдөх ёстой. Ингээд алдагдалтай ажилласан гол шалтгаан бол бид өртгөөсөө доогуур үнээр нүүрсээ худалдан борлуулахаас өөр аргагүй байсан учраас өнгөрсөн жилийн алдагдал үүссэн гэдгийг та бүхэндээ тайлбарлаж хэлэхийг хүсэж байна. Үнийн тухайд та бүхэнд дэлгэрэнгүй тайлбарлая гэж бодож байна. Санхүүгийн үзүүлэлтээс гадна би энэ компанийн өр авлагын байдлыг бас та бүхэнд танилцуулах ёстой. Компанийн авлага 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр бид нийт дүнгээрээ 10,1 тэрбум 30 төгрөгийн авлагатай байгаа компани. Энэ авлага нь үндсэндээ 90 гаруй хувийг буюу 9,5 тэрбумыг нүүрс худалдан авдаг дулааны станцуудаас авах авлага байгаа. Жилийн эцсийн тайлан дүн бол 12 сарын 31-ээр татвар орж гардаг учраас энэ бол Монгол Улсын хамгийн хүйтэн буюу өвлийн оргил үе. Өөрөөр хэлбэл бидний үйлдвэрлэдэг олборлодог бараа бүтээгдэхүүн бол нүүрсний борлуулалтын оргил үе учраас станцуудад бид нүүрсээ өгөөд станцууд маань дараа сардаа багтаагаад өдөрт тооцоогоо хийдэг учраас энэ авлага ер нь өндөр дүнтэй харагдаж байгаа. Энэ бол хэвийн байдлаараа барагдаад явна. Дараагийн буюу нэг тодорхой хэмжээнд 680 орчим сая төгрөгийн авлага бол олон жилийн түүхэнд үүссэн хур буюу хуучин авлагууд байгаа. Энэ бол шүүх хууль хяналтын байгууллагаас шилжээд тендерээсээ мөнгө авлага графикаар барагдаад явж байгаа. Энэ бол 680 орчим сая өглөг. Өр төлбөрийн тухайд та бүхэнд хэлэх ёстой. Санхүүгийн тайлангаараа 2021 оны жилийн эцсээр бид 203,5 тэрбумын өртэй болчихоод явж байгаа. Өнөөдөр 2025 оны 3 сарын 31-ний байдлаар өр орлого маань 13 тэрбумаар буураад 190 тэрбумын өртэй болчихсон явж байна. Саяын 203 тэрбум төгрөгийн өрийг өгдгийг та бүхэнд ингээд задаргаагаар нь тайлбарлаад ойлгуулъя гэж бодож байна. 1 дүгээрт энэ өрийн нэлээн өндөр жинтэй өр бол 75,3 тэрбум төгрөгийн өр байгаа юм. Энэ өр бол хэзээ үүссэн өр вэ гэхээр зэрэг 1998-аас 2000 оны үед Шивээ-Овоо компанийг хөрөнгө оруулалт техникийн шинэчлэлт хийсэн Японы ЗГ-аас зээлсэн зээлийн өр байдаг юм. Урт хугацаанд энэ зээлийн гэрээгээрээ энэ монпэй 5 нь бол төлөгдөж дуусаагүй явж байгаа. Энэ өрийг үүсэхэд ямар асуудал үүссэн бэ гэхээр ЗГ бол 2 үндсэн үүрэг хүлээсэн байдаг. 1 дүгээрт Нүүрсний үнийг өртөгт нь хүргэж нэмэгдүүлэн зарна. 2 дугаарт нүүрсний төлбөрийг цаг тухайд нь төлж барагдуулж авна гэсэн. Ийм 2 үндсэн үүрэг бол хэлсэн байна. Станцуудаас төлөгдөх нүүрсний өглөг бол цаг тухайдаа мэдээж хэрэг энэ он жилүүдэд төлөгдөөд явсан. Харин нүүрсийг алдагдалгүй байлгах буюу өртгийг нь нөхөх хэмжээнд үнийг нь нэмэгдүүлэх асуудлыг бол үе үеийн ЗГ хийгээгүй. Тийм учраас энэ зээл компани өөрөө төлж чадаагүй өдий болтол ингээд далан хэдэн тэрбум төгрөг төлөөд явж байдаг. Та бүхэн мэдэж байгаа монголчууд бид бүгдээрээ хэрэглэдэг цахилгаан дулааны үнэ бол харьцангуй хямд байдаг манай улсад үнийг хямд байлгах иргэд дээр очих ачааг нь бууруулах үүднээс үе үеийн ЗГ-ын шийдвэр бол нүүрсний үнэ болон цахилгаан дулааны үнийг ерөөсөө нэмэгдүүлэхгүй ингээд барьсаар яваад ирсэн. Энэ ч утгаараа энэ салбар маань тэр чигтээ өр төлбөр ийм өндөр хэмжээнд орсон байдаг.

Тэгээд энэ жилээс анх удаагаа ингэж өр төлбөрийг нь хуримтлуулаад үнийг нь хатуу барих бодлогоо больё, зөөлрүүлье гэдэг үүднээс түрүүн миний ярьсан өртөгт нь хүргэх шийдвэр гараад явсан. Энэ бол энэнтэй холбоотой зээл. Дараагийнх нь бүлэг зээл бол дүнгээрээ 64 орчим тэрбум төгрөгийн зээл байгаа. Энэ бол манай толгой компани болох Эрдэнэс Монгол компанийн маань бүрэлдэхүүн хэсэг болох ЭТТ компаниас авсан зээл. Ийм холбогдолтой өр төлбөрүүд байгаа. Энэ өр төлбөрүүд бол яагаад ингэж үүссэн бэ гэхээр нэгэнт өөрийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээсээ доогуур үнээр бид нүүрсээ зарж байгаа учраас алдагдал хүлээх нь ойлгомжтой үйл ажиллагаа доголдох нь ойлгомжтой. Энэ байдлыг нөхөх үүднээс ЭТТ Эрдэнэс Монгол компаниас бидэнд жил болгон өвлийн улиралд зээл өгч байсан. Тэгэхээс ч аргагүй байсан. Энэ зээлүүдийг 1 дүгээрт байгаад 2 дугаарт бас тодорхой хэмжээнд Эрдэнэс Монгол компани менежментийн төлбөр, талбай ашигласны төлбөр гэсэн ийм төлбөрүүд баланс дээр үүсээд гэрээгээр явж байдаг. Энэ бүгд маань нийлэхээрээ 64 орчим тэрбум төгрөгийн өглөг үүсчээд байгаа юм. Эхний 2 дээр ингээд үзэхээр нийтдээ 130 орчим тэрбум төгрөгийн өр. Энэ эхний 1998 оны зээл буюу далан хэдэн тэрбум төгрөгийг уг нь 2018 онд ЗГ-ын хуралдаанд 5 6 удаа орж байгаа тэр Хүрэлсүх Ерөнхий сайдын үед хөрөнгө оруулалт тооцъё гэсэн шийдвэр гараад ЗГ-ын тогтоол гарсан 132 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхийг олон жил, Эрдэнэс монгол компани ЭХЯ-тай хамтраад зүтгээд явдаг, хэрэгжиж өгдөггүй, ингээд байгаад байгаа. Хэрэгжих юм бол энэ өр ингээд манай компанийн данснаас шийдэгдэх, хасагдах бүрэн боломжтой өр байгаа юм. Ингээд дараагийн Эрдэнэс Монгол компанитай холбоотой 60 хэдэн тэрбум төгрөг бол би гүйцэтгэх захирлаар ажиллаж байх хугацаанд Эрдэнэс Монгол компанийн үе үеийн удирдлагууд Эрдэнэс Монгол компанийн ТУЗ-д хүртэл саналаа тавьсан. Охин компани толгой компанийн хувьд нэг удаадаа энэ үеийг ингээд шийдвэрлээд өгчөөч гэж хөрөнгө оруулалт нь өгнө гэсэн хэрэв тэгэх юм бол энэ өөрөө бид бас шийдэх боломжтой гэж хардаг. Тэгэх юм бол бидэнд цаана нь одоо энийг танилцуулах гэж байгаа энэ өр үлдэнэ 60 орчим тэрбум төгрөгийн өр байгаа. Энэ өр бол яах арга байхгүй Шивээ-Овоо компани хэн нэгэнтэй хуваалцах аргагүй. Бид өөрсдөө хариуцах ёстой өр байгаа. Ямар өр байх вэ гэхээр жишээлбэл энэ 2015, 2016 онд манай захирал ажиллахаас өмнө авсан Белаз машины өр явж байна. Бид энийг үйл ажиллагаагаараа төлсөөр байгаад үндсэндээ 2 тэрбумд хүргэчихэж байна. Энэ бол хориод тэрбум төгрөг байсан. Ковидын үеэр авч байсан Японы зээлээр авсан техникийн шинэчлэлтийн 7 тэрбум төгрөгийн өр байгаа гэх жишээтэй. Энэ үйл ажиллагаатай холбоотой өр байгаа. Энэ өрийг бид жил болгон үйл ажиллагааныхаа орлогоос төлөөд явж байгаа. Энэ дээр нэг зүйлийг хэлэхэд энд би та бүхэн ингээд Нүүрсний үнийг индексжүүлсэн тохиолдолд бид энэ 60 гаруй тэрбум төгрөгийг бид 3-аас 4 жилийн дотор төлөх бүрэн боломжтой. Нүүрсний үнийг индексжүүлсэн тохиолдолд. Энийг би яагаад ингэж зоригтой хэлж байна вэ гэхээр түрүүн та бүхэнд би хэлсэн нүүрсний үнийг анх удаагаа өөрийнх нь өртөгт буюу алдагдалгүй хэмжээнд нь аваачаад нэмчихсэн байсан. Ингэж нэмэхдээ зүгээр нэг удаа нэмээд орхичих юм бол мэдээж хэрэг энэ валютын ханшийн өсөлт инфляцын түвшин жил болгон 6-аас 7% явдаг гээд ингээд үзэхээр 1 жил мөрдөөд дараагийн жил нь дахиад алдагдал руу орох учраас эрчим хүчний зохицуулах хороо шийдвэр гаргахдаа цаашид жил болгон индексжүүлж явъя гэсэн. Өөрөөр хэлбэл жил болгон тодорхой хэмжээнд инфляцын түвшинтэй уялдуулаад 6-аас 7%-аар энэ үнийг тогтоосон. Үнийг нь өсөөд явъя гэсэн. Хэрэв тэгж явах юм бол компани цаашид алдагдалгүй ажиллах бүрэн боломжтой, алдагдалгүй ажиллана. Энэ өр төлбөрөө төлнө, ашигтай ажилласан тохиолдолд мэдээж хэрэг ногдол ашиг оруулах тухай яриад анх удаагаа гаргахаар ийм боломжит шийдвэр гарсан байсан. Саяын үнийн өөрчлөлтөөр. Тийм учраас бид цаашид үнийг ингээд индексжүүлээд, өсгөөд, ингээд хэвийн явах юм бол бид энэ өр төлбөрөөсөө салах өөрөөр хэлбэл миний саяын хэлсэн энэ зүйлүүд хэрэгжих юм бол Шивээ-Овоо компани өр төлбөргүй болох ийм бодит боломж бас бий болохоор харагдаж байгаа гэдгийг бас та бүхэнд хэлье. Дараагийнх нь үйлдвэрлэлээс хангах үндсэн үзүүлэлт сүүлийн 4 жилээр байна. 2022-2025 он хүртэл борлуулалт бол ямагт өсөж байгаа. Сүүлийн жилүүдэд 2025 он гэхэд бид 2 сая 750 мянган тонн захиалга авсан байсан.

Оны өмнө төлөвлөгөөг боловсруулахдаа өнөөдрийн байдлаар эргээд буурах хандлагатай болж байгаа. Яагаад гэхээр өнгөрсөн өвөл харьцангуй их дулаан байсан учраас станцууд нүүрсний хэрэглээ их бага хэрэглэсэн. Дээр нь одоо бас үнэ нэмсэн асуудал нь л нэлээн нөлөөлсөн байх. Яагаад гэхээр уурхайгаас нийлүүлэгдэж байгаа нүүрсний үнэ нэмэгдсэн учраас станцууд бас нүүрснийхээ хэрэглээн дээр нэлээн хязгаарлалт хийсэн болов уу гэж миний зүгээс бас харж байгаа. Та бүхэн мэдэж байгаа байх Бөөрөлжүүтийн цахилгаан станц Багануурын цахилгааны батарей хураагуур гээд. Ингээд цахилгаан эрчим хүчний төлөвлөгөө гээд. Ингээд шийдлүүд гарсан учраас үйлдвэрлэлийн хэмжээ түр 2025 онд бага зэрэг буурах ийм хандлага байгаа учраас нүүрсний нийлүүлэлт жоохон багасаж байгаа юм. Хөрөнгө оруулалтыг түрүүн танилцуулсан. Өр авлагыг танилцуулсан санхүүгийн үзүүлэлтээ бас танилцуулчихсан байгаа. Нүүрсний үнийн өөрчлөлт та бүхэнд харуулъя гэж бодсон юм. 2014 оноос хойших нүүрсний үнийг өөрчлөлтөөр нь харуулчихсан байгаа 2014 онд жишээлбэл Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт нүүрс нийлүүлж байгаа 3 гол уурхай байгаа юм. Энэ бол Шарын гол, Багануур, Шивээ-Овоо, Шарын голын үнэ бол жишээлбэл 2014 онд 30 мянга Багануурын 25,500 1 тонн нүүрс зарж байгаа үнэ тэгээд Шивээгийнх хэд вэ? 21,060. Хамгийн бага үнэтэй энэ үнийг яагаад ингэж бага тогтоодог юм бэ гэхээр танай Шивээ-Овоогийн нүүрс илчлэг багатай гэсэн ийм тайлбарыг эрчим хүчний зохицуулах хороо ЭХЯ өгдөг. Энэ бол үнэн. Өнөөдрийн байдлаар Шивээ-Овоогийн уурхайг олборлож байгаа нүүрс бол улсынхаа стандартаар 2750 бид станцуудад гэрээ хийгээд нийлүүлэхдээ яаж ийж байгаад өөр бусад арга хэмжээ авч байж 3 мянган кил калори илчлэгтэйгээр нэг тонн нүүрс өгдөг. Тэгэхээр тэрийг үндэслээд энэ үнийг ингэж бага тогтоогоод байдаг. Би гүйцэтгэх захирлын ажил авснаас хойш бол дээр нь байгаа хөрсийг хуулаад шороог нь зайлуулаад доороос нь нүүрс гаргахад тэр доор байгаа нүүрс одоо чанар илчлэгийн хувьд бага байна уу их байна уу бид адилхан зардал гаргаж байгаа юм. Адилхан зах зээл дээр ажиллаж байгаа учраас бид энэ уурхайнуудаас бага үнээр бид нүүрсээ олборлох боломжгүй гэдэг тайлбарыг удаа дараа хэлсэн. Тэгээд олон жил нөгөө миний эрх мэдэл хүрэх биш тэр шийддэг газрууд бол дандаа ялгавартай яваад байсан. Сая та бүхэнд танилцуулсан 2024 оны 12 сард гарсан шийдвэр дээр нүүрсний үнэ ингэж ойртож ирсэн. Шарын гол бол 65,315 төгрөгөөр Багануурт 54,091 төгрөгөөр нэг тонн Шивээ-Овоо, 53,197 төгрөг төгрөгөөр анх удаагаа энэ олон он жилүүдэд бид 830 орчим төгрөгөөр энэ албанаасаа арай бага өөрөөр хэлбэл яг одоо энд халуун ам бүлээрээ байгаа дээрээ хэлэхэд бид анх удаагаа нүүрснийхээ үнийг энэ түвшинд аваачиж ойртуулж чадсан. Хэрвээ Багануурынхтай адилхан үнээр Шивээ-Овоо зардаг байсан бол бид өнгөрсөн жилүүдэд ч гэх шиг бас нэлээн бас 1 3 4 жилд нь хүртэл бид нар алдагдалгүй ажиллахаар ийм дүр зураг байдаг юм. Санхүүгийнхээ тайланг гаргахаар тэгэхээр яасан бол? Энэ 2024 оны 12 сард гарсан шийдвэрээр бол бид өртөгт нь хүргэсэн үнийн нэмэгдэл дээр бол Баганууртай маш ойрхон очсон. Энэ үнээрээ цаашид мөрдөөд явахад Багануурынхаа хэмжээнд ажиллах амьдрах ийм боломж бүрдэнэ гэж харж байгаа. Гэтэл сая 4 сард Эрчим хүчний зохицуулах хороо эргэж хуралдаад нүүрсний үнийг дахиад буулгасан 53,197 байсан 50,537 болсон. Ингэхдээ 3 уурхайгаас 3-ууланг нь яг адилхан 5% нь энд оруулсан. Ямар шалтгаан байсан бэ гэхээр цахилгааны үнийг нэмчихсэн. Тийм учраас манайх нөгөө үнийг нэмчихсэн 11 сард дулааны үнийг бол нэмээгүй байсан дулааны үнийг нэмэх шийдвэрээ эрчим хүчний зохицуулах хороо хойшлуулсан. Тийм учраас дулааны үнэ нэмэгдээгүй учраас бидэнд өгөх бидний нүүрсний үнийг буцаагаад нөгөө тэрүүнтэй холбоотойгоор буулгасан юм шүү. Тэгээд энэ бол ирэх жилээс гайгүй болох байх гэсэн ийм төлөөлөлтэй байгаа. Гэхдээ бид 38,990-ээр зарж байсан хүмүүс шүү дээ. Одоо 50 мянга зарж эхлэхээр бас арай учиртай байгаа. Энийг хамгийн бага үнээр нүүрсээ зарж явдаг байсан шүү гэдгийг та бүхэнд ойлгуулах үүднээс яг бодит он сартай нь үнэ зодогтой нь ингээд та бүхэнд танилцуулж байгаа шүү. 2024 онд уурхайн тасралтгүй үйл ажиллагааг явуулах өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд бид ингээд төлөвлөсөн төлөвлөгөөнийхөө дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан. Энд 334 төрлийн бараа материал ажил үйлчилгээг 86,9 тэрбум төгрөгөөр

худалдан авахаар хөрөнгө оруулалтад илүү өөр 27 төрлийн бараа ажил үйлчилгээг 37,6 тэрбум төгрөгөөр худалдаж авахаар төлөвлөгөө хийгээд батлуулаад ажилласан. Гүйцэтгэлээр 82,5 тэрбум төгрөгийг нийт бараа ажил үйлчилгээг худалдаж авсан энэ 4,3 тэрбум төгрөгийн хэмнэлттэйгээр худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан гэсэн ийм дүнтэй ажилласан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу би та бүхэнд танилцуулсан тэр техникуудийг энд худалдаж авсан. Авто зам сумаар 4 ширхэг ачигч 3 ширхэг тетриток дотроос тэр 3 гээд уурхайд нэн шаардлагатай байгаа ийм техникуудийг хөрөнгө оруулалтаараа бид худалдаж авсан гэдгийг бас та бүхэндээ дуулгая. Тэгээд би түрүүн нөгөө хурал эхлэхээс өмнө та бүхэнд хэлж байсан хувьцаа эзэмшигчдийнхээ хувьд хувьцаа эзэмшигчдийнхээ нөгөө уурхайтай танилцах ийм хөтөлбөр аяллуудыг зохион байгуулж байгаа. Эхний ээлжид явчихсан хүмүүс байгаа. Тэр хүмүүс очоод энэ техникуудээ одоо ингээд бүүр ингээд үзэж хараад зарим сонирхогч нар нь сууж үзээд ингэх боломжтой байгаа. Дараагийн ээлжийнхийг би 5 сард зохион байгуулахаар шийдвэрлэж байгаа. Тэгээд сүүлд хоцорч ирсэн улсууд байвал энэ зарыг бас мэдээд аваарай. Тэгээд 5 сард нэг боломжит өдрөөр бид унаа тэргээр ирж аваад уурхайгаа үзүүлээд нөхцөл байдалтайгаа та бүхэнд танилцуулах ийм бодолтой байгаа шүү. 2024 онд хөрөнгийн биржээс нээлттэй ХК-удын засаглалын хэрэгжилтийг үнэлж дүгнэдэг байгаа. Тэгээд энэ үнэлэлтээр манай компани засаглалын хувьд топ 20 компанийн нэгээр шалгарсан байгаа 16 дугаар байр. Та бүхэндээ бас нэг анхаарлыг нь хандуулаад ярьчихъя гэж бодож байгаа нэг зүйл байгаа. Бид 590, 600 сая орчим тооны нөөцтэй гэсэн. Тэгэхээр энэ бол нөөцтэй холбоотой зүйл биз дээ? Энэ юу вэ гэхээр Эрдэнэс Монгол компани Шивээ-Овоо ордын шинэ усны хэсэг дээр байгаа төрийн эзэмшлийн талбайг ашиглалтын лицензийг эзэмшдэг нэг компани байгаа манай толгойн компани. Тэгэхээр Эрдэнэс Монгол компанийн зүгээс олон улсын стандартад нийцсэн жорк стандарт гэж ярьдаг. Энэ стандартаар нөөцөө тогтооё гээд хайгуулын ажил гүйцэтгэж байгаа. Өнгөрсөн 2024 онд эхний ээлжид хийгдсэн 2025 онд 2 3 дугаар ээлж хийгдэхээр ордын нөөц бүрэн тогтоогдоно гэсэн үг. Хуучин социализмын үед хийгдсэн хайгуулаар та бүхэн учир дутагдалтай нөөц тогтооход эргэлзээтэй мэдээллээр хийгдсэн, дутуу хийгдсэн гэсэн үг товчхон байгаа юм. Одоо бол ийм чиггүй байдлаар хийж байгаа. Тийм учраас олон улсын стандартаар хайгуул хийгдэж дуусгаад нөөц маань бүрэн хэмжээгээр тогтоогдоно гэсэн үг шүү. Эхний хайгуулын ерөнхий зураг энэ байна. Иймэрхүү байдлаар уурхайн холболт явуулж байгаа талбайн улаан цэгээр тэмдэглэсэн хэсгүүд дээр дүгнэлтээр 2007 онд 800 3 мянга хүргэх гэж нэлээн ажил болдог нүүрс бид өнөөдөр олборлож байгаа хайгуулын дүнгээр цаашид бид 4 мянга гаруй илчлэгтэй өөрөөр хэлбэл Багануураас бага илчлэгтэй гэж яваад байдаг нүүрс маань өндөр илчлэгтэй болох нь гэсэн ийм хүлээлт байгаа шүү гэдгийг бас та бүхэнд хэлье. Энэ хайгуул гүйцэт хийгдсэний дараагаар манай нөөц бол дэлгэрэнгүй болно гэсэн үг. Энэ ногооноор тэмдэглэсэн газар бол бид 2023 онд оруулаад цахилгаан станц барих зориулалттай газар байгаа. Цахилгаан станц энэ МАН-ын мөрийн хөтөлбөрт байгаа ЗГ ч бас энэ тал дээр нэлээн бас өөрийн алсын хараа 2 хүнтэй ажиглуулагдсан байгаа. Энэ хувийн эзэмшлийн уурхайнууд дээрээ Цахилгаан станц барилга төсөл хөгжүүлэе гэж яригдаж байгаа хэрэгжүүлэх газар нь бол уурхайн хажууд байгаа уурхай дээр маань бас ирээдүйд цахилгаан станц баригдвал бидний бас энэ олборлолт, хэмжээ, борлуулалт өсөх боломжтой байгаа гэдэг үүднээс та бүхэнд мэдээллийг өгч байгаа юм. Уурхайн тухайд компанийн тухайд тулгамдаж байгаа асуудлуудыг бас газрын ажилчдыг танилцуулъя гэж бодож байна. 1 дүгээрт түрүүний миний ярьсан ЗГ-ын тогтоолоор шийдүүлэх ёстой 73 сая төгрөгийн өр байгаа юм. Энийг төрөөс оруулсан хөрөнгө оруулалт маягаар шийдэх ийм боломж байгаа. Тэгээд энэ чиглэлээр Эрдэнэс Монгол компани, Шивээ-Овоо компани, манай ТУЗ бид бүгд хамтраад хөөцөлдөж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Өр авлага дээр ярьсан 60 орчим тэрбум төгрөг Эрдэнэс Монгол компанитай холбоотой толгой компанийн хувьд манай компанид нэгийг одоо зүгээр ний нуугүй хэлэхэд тусламж болгон хүнд үед нь зээлүүлж байсан ийм хөрөнгөөр зээл байгаад байгаа юм 62 тэрбум энийг бас шийдэх ийм боломжтой гэж ингэж үзэж байгаа энэ 2 бидний хувьд тулгамдсан асуудал гэж

өнөөдөр бид харж байгаа юм. 3 дахь асуудал бол мэдээж уурхайгаа бас өргөжүүлэх хөгжүүлэх. Компанийн хүчин чадал нэмэгдүүлэх үүднээс уурхай дээр түшиглэсэн цахилгаан станц бол зайлшгүй шаардлагатай. Ингэж байж уурхай нэлээн ашиг орлого үйл ажиллагаа өргөжих ийм боломжтой байгаа учраас энэ бол манай том зорилтын нэг. 4 дэх бол яах вэ? Энэ бол ЗГ-ын мэдүүлэг гэж хэлсэн. Яагаад гэхээр та бүхэн бас нэг мэдээлэл авчихад бид бол нүүрсээ үндсэндээ УБТЗ-ын вагоноор Улаанбаатар луу зөөдөг УБТЗ маань ердөө хуучин вагонууд нь актлагдаад байгаа учраас та нар вагоноо өөрсдөө ол гэдэг. Бид нар вагон олох ямар ч боломжгүй ийм албан бичиг ирүүлчихсэн тэгээд манай 2 хоорондоо тэгээд өвөл болохоор учраа олоод ямар ч байсан станцуудаа нүүрсээр хангаад та бүхнийгээ гэрэл тогоор тасалчихгүй өвөлжих байх гэж найдаж байгаа. Тийм учраас энэ асуудал манайхан дээр ямар нэг байдлаар шийдээд явах байх гэж бодож байна.

Компанийн үйл ажиллагааныхаа талаар товч танилцуулгыг та бүхэндээ хүргүүлье. Үйл ажиллагааны талаар Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя. Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн тогтоол 2025 оны 4 сарын 23-ны өдөр дугаар 25/16 тоот компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт гаргах тухай Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалт Шивээ-Овоо ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4.2.8-д заасан тус тус үндсэн тогтоох нь 1. Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлагатай гэж дүгнээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд даалгасугай. 2 компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг мэдээлэх ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал Энхтүвшинд үүрэг болгосугай. Дарга Д.Нямдэлгэр гэсэн ийм тогтоол байгаа гэдгийг та бүхэнд танилцуулъя. Компанийн 2024 оны үйл ажиллагааны талаар та бүхэнд танилцуулахад ийм байна. Асуулт байвал хариулна.

Хувьцаа эзэмшигч:

Хувьцаа эзэмшигч гишүүн Энхтуяа гэж хүн байна. Сая тайлан дээр гарлаа. Өнгөрсөн улиралд нэг ч тээвэргүй гээд тайлбар өгнө үү?

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Энэ ийм учиртай манай уурхай бол та бүхэн мэдэж байгаа социализмын үеэс байгуулагдаад Багануур ч тэр. Яг ийм системд явдаг. Яагаад гэхээр ЗХУ-д үйлдвэрлэсэн экскаватор гэдэг ийм экскаватор ашигладаг юм. Тээвэртэй системээр яадаг вэ гэхээр би зүгээр энгийн байдлаар тайлбарлаж байгаа юм. Тээвэртэй системээр яадаг вэ гэхээр энэ доголудыг бид гидро экскаватор буюу цахилгаанаар ажилладаггүй, түлшээр ажилладаг, хаана ч очоод ажилладаг тийм экскаваторыг ийм системээр аваад тээврийн машинаар энэ овоолуур үүсгэнэ гэсэн үг. Дараагаар нь энэ талбайгаа бэлдчихэж байгаад алхаж экскаватор гээд уурхай дээр очсон хүмүүс бол мэднэ. Том экскаватор, тэр экскаваторыг цахилгаанаар ажилладаг яадаг вэ гэхээр олборлолт явагдаад нүүрс авчихсан орон зай үүсдэг. Өөрөөр хэлбэл газар ухаад бид хөрсийг нь зөөгөөд нүүрсийг нь аваад явчихаар тэр энд орон зай үүснэ шүү дээ. Тэр орон зай руугаа нөгөө алхаж экскаватор маань цахилгаанаар ажилладаг том экскаваторууд байгаа. Тэр 2 экскаватор байна. Манайд 11 70 25.1 нь 90м3 шанагатай нэг нь 70м3 шанага, 25м3 шанагатай 90 метр зайд. Одоо хөрс шороогоо зүлгэнэ. Нэг нь 11м3-ын шанагатай далан метр зайд. Энэ экскаватор бол яадаг вэ гэхээр энэ хоосон орон зайд нүүрсний дээд давхарга бол байгаа шороог зөөгөөд л хийгээд л байсан, ерөөсөө тээвэрлэхгүй өөр өөрийнхөө байгаа газраас нь дараагаар нь шаардлагатай дахиж зайлаад дахиад шидсэнийгээ дахиад цааш нь зэрэг ийш нь зөөгөөд энийг л тээвэргүй систем тээвэргүй гэдэг экскаватор өөрөө ухаад хажуу тал руугаа тавиад байна л гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч:

Одоо баялгийн санд юм өгөх болж байгаа биз дээ? Тийм ээ? Тэгэхээр зэрэг энэ чинь их өр зээл бас байна л даа тэгээд ер нь өр зээлээ бас шийдвэрлэх талаар нэлээн

хөөцөлдөж байгаа юм болов уу гэж ойлгож байна тэгэхгүй бол баялгийн сан чинь юу өгөх вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Тийм. Баялгийн сангийнхаа хуулиар стратегийн ордууд тийм заалттай. Их хурал ЗГ-ын шийдвэр гараад л явах байх. Бид яасан бэ гэхээр стратегийн орд мөн. Нөөцөөрөө ч тэр үйл ажиллагаагаараа ч тэр үүрэг хариуцлагаараа ч тэр. Яагаад гэхээр Монгол Улсын эрчим хүч дулааныг үндсэндээ үүрч байгаа 2 уурхайн нэг. Тэр утгаараа бол бид стратегийн орд маань түрүүний хэлдгээр өр төлбөрийнхөө асуудлыг бид байнга хөөцөлдөж байгаа. Цаашид бидний зорилго компанийн зорилго бол бид ашигтай ажиллах ёстой хувьцаа эзэмшигчдэдээ ч гэсэн ашиг ногдол өгч байх ёстой стратегийн ордын хувьд баялгийн санд ч гэсэн бид хуримтлал үүсгэх ёстой энэ бол бидний зорилго энэний төлөө л ажиллах ёстой юм байгаа юм.

Хувьцаа эзэмшигч:

Уурхай ажилчдаа яаж тогтоон барих гээд байгаа юм? Тэр санал дээр байна уу?

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Ер нь сүүлийн жилүүдэд уурхайн хөгжил нэлээн өндөр болсон. Өмнөговьд өчнөөн уурхай нээгдсэн тийшээ мэдээж мэргэжлийн боловсорсон инженер техникийн ажилтнууд мэргэжлийн чадварлаг операторууд явах ийм үзэгдэл манайд их гарсан. Жилд 500-аад хүн хүртэл ажлаас орж гарах тогтсон тоогоор ийм үзүүлэлт хүртэл гарч байсан. Энэ юутай холбоотой вэ гэхээр 1 дүгээрт бидний борлуулж байгаа нүүрсний үнэ өртөгтэй холбоотойгоор бид харьцангуй бага цалин өгдөг. Тэгэхээр бидний амьдарч байгаа гол эх үүсвэр нь бол юу вэ? Цалин. Тийм учраас тэр хүмүүсийн буруу гэж ерөөсөө байхгүй. Хаана цалин өндөр өгнө амьдрал ахуйгаа бодоод явалгүй яадаг. Энэ талаар одоо манай компанийн ТУЗ, Эрдэнэс Монгол компани бид хэд бас нэлээн тодорхой ажлуудыг өөрсдийнхөө боломж бололцоогоор авч хэрэгжүүлж байгаа. Сая нүүрсний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулаад бид цалингаа бас жоохон нэмсэн тэгээд яг өнөөдрийн тухайд энэ хил гааль нүүрс экспорт гарахаа байсантай холбоотой ч байна 1 2 дугаарт бидний бас нэг нүүрсний үнэ жоохон нэмэгдэнгүүт нөгөө ажилчид ажилтнууд дунд маань бас хүлээлт үүсэж байна шүү дээ. Одоо бас нэг компаниуд гайгүй болох болов уу сайжрах болов уу? Тийм байдалд байгаа. Тийм учраас бид цаашид ажилчдаа бас тэр мэргэжлийн чадварлаг боловсон хүчин нийт капиталаа тогтоохын тулд тодорхой арга хэмжээнүүд авч ажиллана аа л гэж ингэж бодож байгаа шүү. За өөр асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч:

Төмөр зам болбол одоо ингээд ажилчдаа байр цалин мөнгө. Тэгээд байр хувьчлагдчихсан сураг байгаад байсан. Хувьчлаад буруу яваад байна уу

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Хувьчлах нь бол зөв байсан байх даа. Яагаад гэхээр социализмын үед байгуулагдсан үйлдвэр уурхай бүгд хувьчилсан юм байна лээ. Бүгд ганцхан шивээ үлдчихсэн. Жишээлбэл 20 30 жил амь насаараа амьдарчихсан өндөр настныхаа тэтгэвэрт гарахаар нөгөө байраа тушаах болдог гэхээс өгсүүлээд 1 2 дугаарт залуу ажилтан мэргэжилтэн боловсон хүчнүүд тэнчээнээс нь 5 6 жил ажиллачихсан байдаг. Бас нэг өөрийн гэсэн байртай больё гээд ингээд олон жил гарсан хүсэлт юу байдаг юм тэгээд? Тэр дагуу 18 онд нөгөө ТУЗ, ХЭХ-аараа дамжуулаад шийдээд хувьчилсан. Хувьчлагдаагүй үлдсэн 50 60 байр бол байдаг юм манай дээр одоо нөгөө компанийн ажилтнууд амьдарч байгаа. Нөгөө ядуугийн зовлон гэдэг чинь хөрөнгө мөнгөгүй л байгаад байгаа юм л даа. Тэрнээс хөрөнгө мөнгөтэй бол бид цаашид бас ажилчдын ялангуяа нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, нарийн мэргэжлийн гагнуурчин хүртэл хэрэгтэй шүү дээ. Бид гагнуурчинд бас сая байр өгөхөөр зүтгээд дотроосоо зохицуулалт хийж байна гэх жишээтэй. Ийм улсуудыг ялангуяа эхний

ээлжид би байраар хангах ёстой. Ийм чиглэлээр ирэх жилээс тодорхой хэмжээнд цөөхөн ч гэсэн орон байрны асуудал шийдье гэсэн ийм бодол байгаа.

Хувьцаа эзэмшигч:

Жорк олон улсынхаа стандартыг нэг ойлгомжтой тайлбарлаач

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Энэ бол Австралийн мөрддөг стандарт байгаа. Уул уурхайн өндөр хөгжсөн. Хуучин хийгдсэн хайгуул 1986 онд 1987 онд энд яасан бэ гэхээр энэ бурууг та бүхэн харж байгаа бол жишээлбэл өрөмдлөгийн цэгүүд гэсэн үг. Энэ шугамын хооронд гэхэд одоо 500 метр энэ цэгүүдийн хооронд гэхэд ахиад 300 100 метр ийм байгаа. Тэгэхээр яах нь вэ? Мэдээлэл хөдөлгөөнөөс зөрөөтэй гарах магадлалтай олон улсын теором стандарт гэдэг бол энэ та бүхэн харж байна. Хоорондын зай алга тэгээд утаа метр нь 280 орчим метртэй өрөмдөж байгаа. Ингэж нарийн системтэй батлагдсан стандартынх нь дагуу хийж байгаа учраас тэр чинь нөөцөө маш өндөр магадлалтай тогтооно гэсэн үг. Товчхондоо нөгөөдөх хоорондоо яах нь харагдаж байгаа биз дээ. Нөгөө вагонуудад бас оролцоотой юм шиг байна лээ шүү дээ. Тэгээд л гол нь тээврийн зардлыг нь танай тал дээр үлдээхээр бол бас 1 дүгээрт тэрийг худалдаж авах хөрөнгө байхгүй 2 дугаарт вагон чинь таны төсөөлж байгаа биш тэрийг маллана агуулна гэдэг чинь ахиад УБТЗ шиг гээд тийм том компанийн бид зүйлсээ олборлоод л гаргаад л ачиж өгөх л үүрэгтэй.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Өнөөдрийн хурлыг зохион байгуулж байгаа комиссын бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Бид санал хураалт явуулах болохоор. Өнөөдрийн хурлыг бэлтгэх зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн комиссын дарга Ч.Энхжаргал компанийн Захиргаа хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, гишүүдээр Солонго ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Мандахнаран хуулийн зөвлөх, Гэрэлтуяа хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцахын мэргэжилтэн. Дэлгэрэх мэдээлэл технологийн ахлах инженер, Дараагийн комиссын бүрэлдэхүүн хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн комиссын даргаар Мандахнаран хуулийн зөвлөх, гишүүд Энхтөр Төлөвлөлт эдийн засгийн албаны дарга, Урантөгс хөдөлмөрийн эдийн засагч. Бүрэлдэхүүнийг ТУЗ-өөс томилж баталсан байгаа. Дараагийн асуудлын талаар хэлэлцье.

Хурлаар хэлэлцсэн нь:

2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Шийдвэрлэсэн нь:

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

2024 оны санхүүгийн тайланг танилцуулъя. Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, орлого, зарлага, алдагдлын талаар та бүхэнд үйл ажиллагааны тайлан дээр түрүүн бас хүснэгтээр тайлбарлачихсан. Энэ дээр хуулийнхаа дагуу манай Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд төрийн аудитаас хийсэн аудитын тайланг та бүхэнд танилцуулж байна. Аудиторын шалгалт шийдвэр хийхдээ хуулийнхаа хугацаанд явагддаг байгаа. Тайлангийн дүгнэлт тайлангаар бид санхүүгийн хувьд бол өөрчлөлтгүй дүгнэлт өөрөөр хэлбэл стандарт дүгнэлтийг авсан байгаа. Дүгнэлтийн тухай эхний хэсгийг нь та бүхэнд гол хэсгийг нь уншаад танилцуулчихъя гэж бодож байна. Үндэсний Аудитын газар 2025 оны 3 сарын 12 дүгнэлт ирсэн байгаа. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1.1 8 дугаар зүйлийн 8.1. 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан

бодох бүртгэлийн бодлого тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал тайлан жилийн эцсээр санхүүгийн үр дүн мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна ийм байдлаар өөрчлөлтгүй дүгнэлтийг төрийн аудитын байгууллагаас хийгдсэн санхүүгийн тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан. Та бүхэнд тараасан материаллаг дэлгэрэнгүй баримтуудыг бүгдийг нь уншаад алгасчихъя гэж ингэж бодож байна. Өмчийн өөрчлөлтийн тайлан болж байна. Мөн санхүүгийн тайлангийн аудитаар бол зөвлөмж, албан шаардлага өгсөн байгаа. Энийг хуулийнхаа дагуу бид хүлээж аваад хэрэгжүүлэх ийм төлөвлөгөө боловсруулаад энийгээ хэрэгжүүлээд энэ алдаа дутагдал юмнуудыг засах ёстой байдаг. Энэнийхээ төлөвлөгөөг гаргачихсан байгаа. Жишээлбэл компанийн бүтэц зохион байгуулалт уялдаагүй байгаагаас дотоод хяналтын тогтолцоо суларсан байна. Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил дутагдал зарим талаар батлагдаж байна гэсэн ийм зөвлөмж ирсэн байгаа. Зөвлөмжийн дагуу бид хийж хэрэгжүүлэх ажлаа 4 сарын 17-н хүртэл аудит гаргаад хүргүүлчихсэн энэ дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллаж байгаа. Үндсэн хөрөнгийн үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 51,3 тэрбум төгрөгийг элэгдлээр анхны өртгөөр нь хүртэл үлдэх үрдэггүй 2085 ширхэг хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх гэсэн ийм зөвлөмж ирсэн байгаа. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль стандартынхаа дагуу бид хийж хэрэгжүүлж байгаа. Тайлант санал буюу 2024 онд 12,1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас энэ 12,1 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 102.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар оны эцэст баталгаажуулаагүй байна гэж байгаа. Хугацаанд нь баталгаажуулаад аудит шаардлагынх нь дагуу хүргүүлж байгаа. Өмнөх онуудад төлөгдсөн 102 тэрбум төгрөгийн найдваргүй авлагыг тохируулах бичилтийг санхүүгийнхээ бүртгэл тооцоон дээр хийгээгүй байна гэсэн зөвлөмж ирсэн. Залруулга бичилтийг хийгээд явж байгаа гэдгийг хэлье. Урьдчилж төлсөн зардал тооцоо, дансны үлдэгдэл 411,7 сая төгрөгөөс олон жилийн насжилттай 326 26,2 сая төгрөгийн үлдэгдэл тооцоо байна гэж. Энэ дээр авах нь шаардлага бөгөөд олон жилийн насжилттай тэр орлого тооцоог шүүхийн байгууллагад шилжүүлж байгаа. Шүүхээс илүү хуулийн байгууллагад. Компанийн ажилтан бус ҮЭХ-ны даргад үр дүнгийн шагналт цалин олгосон нь хуульд нийцээгүй байна гээд акт тавьсан. Манай ажилчнаас сонгуулиар сонгогдсон үйлдвэрчний хорооны дарга юм байгаа юм. Тэгээд урамшуулалт цалин авсан тэр нь буруу гэж үзсэн. Актыг бид барагдуулаад хуулийнх нь дагуу олгож ажиллаж байгаа. Олон жилийн насжилттай 460 орчим сая төгрөгийн сэлбэг энэ агуулахад энэнийхээ ашиглалтыг шийдвэрлэ гэсэн. Тэгээд энэнийх нь дагавал акт гэсэн хуучин техникүүдтэй холбоотой учраас энийг нь бид нар бусад байгууллагуудад компанийнх судалгаа явуулаад худалдан борлуулах ийм үйл ажиллагааг аудитын өгсөн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлж байгаа гэдгийг хэлье. Тайлант хугацаанд 4,3 сая төгрөгийн 11 худалдан авалтыг нөгөө нээлттэй тендер шалгаруулалтад явуулалгүйгээр хийгдсэн байна. Өнгөрсөн жил 230 мянган тонн хөрсийг төлөвлөгөөнд ороогүй зүйлийг хийж станцуудад дугуйлан өгсөн юм байгаа юм. Энэнтэй холбоотой хийгдсэн хөрс хуулалтын ажлыг гаднын техникээр гүйцэтгүүлсэн ийм гэрээнүүд энийг хуулийнхаа дагуу бид АТГ-т бүгдийг нь материалаар нь хүргүүлээд тэнд хянуулж байгаа гэдгийг хэлье. Шилэн данс дээр бид нар хөрөнгө оруулалтынхаа төлөвлөгөөг оруулаагүй ийм зөрчил бас гарсан байсан. Аудитын байгууллага та нар бүрэн оруулах ёстой гэсэн шилэн дансны хуулийг уг нь манай компани тодорхой хэмжээнд нэлээн сайн мөрдөж ажилладаг компани юм. Бидний хариуцлагагүйгээс болоод хөрөнгө оруулалтынхаа төлөвлөгөөг оруулаагүй ийм зөрчил гарсан байсан. Ерөнхий санхүүгийн үйл ажиллагааг та бүхэндээ танилцуулчихсан. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Төрийн аудитын дүгнэлтийг бас та бүхэнд зөвлөмжтэй нь танилцуулчихлаа. Одоо энэ санхүүгийн тайлангийн дүгнэлттэй холбоотой ТУЗ-ийн тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулъя. Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн тогтоол 2025

оны 4 дүгээр сарын 23-ны өдөр дугаар 25/15 Улаанбаатар хот компанийн 2024 оны санхүүгийн тайлан дүгнэлт гаргах тухай Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт Шивээ-Овоо ХК-ийн 4.3 дугаар зүйлийн 3.4.2.8-д заасныг тус тус үндэслэн тогтоох тогтоох тухай. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт Шивээ-Овоо ХК-ийн 4.3 дугаар зүйлийн 3.4.2.8-д заасныг тус тус үндэслэн тогтоох нь нэг Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнээд Үндэсний Аудитын газраас Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн хамт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд даалгасугай. 2. Үндэсний аудитын газраас Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмж актыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд үүрэг болгосугай. 3 Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо Ц.Лхамсүрэнд даалгасугай. Дарга Д.Нямдэлгэр гэсэн ийм тогтоол гарсан байгааг та бүхэндээ танилцуулъя. Ингээд санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг та бүхэндээ танилцуулж дууслаа. Асуулт тодруулга байвал хариулна.

Хурлаар хэлэлцсэн нь:

3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан шийдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Хэлэлцэх асуудлын 3-д ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулна. Энхтүвшин захирлыгаа урьж байна.

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Та бүхэндээ ноогдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолоо танилцуулъя. Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн тогтоол 2025 оны 2 дугаар сарын 19-ний өдөр дугаар 25/05 Улаанбаатар хот ноогдол ашиг хуваарилах эсэх тухай Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 47 дугаар зүйлийн 47.1.1.1 дэх заалт Шивээ-Овоо ХК-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУЗ-өөс тогтоох нь Нэг Шивээ-Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангаар ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх нөхцөлийг хангахгүй байх тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй. 2. Энэ тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд үүрэг болгосугай. Тогтоолыг та бүхэнд танилцууллаа. Түрүүн би та бүхэнд үйл ажиллагааны тайлан дээр ерөнхийд нь танилцуулж байсан. Яагаад бид ноогдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бэ гэхээр бид алдагдалтай 2024 онд ажилласан 2024 онд хариуцдаг алдагдал маань 14,2 тэрбум байгаа. Тайлан яагаад бид ийм алдагдалтай ажилласан бэ гэхээр та бүхэнд хэлсэн 1 дүгээрт бид өртгөөсөө доогуур үнэ зарцуулдаг 2 дугаарт Багануураас гэхэд бид 4440 төгрөгийн доогуур зарж байсан ямагт 4440 төгрөгийг жишээлбэл энэ бид нарын борлуулсан 2 сая 600 мянган тонн нүүрсээр үржих юм бол энэ 10 хэдэн тэрбум төгрөг зөвхөн Багануур Шивээ-Овоогийн үнийн зөрөөн дээрээс л гарч байгаа. Анх удаагаа би түрүүн хэлсэн энэ өртөгт нь хүргэсэн үнэ тогтоогдсон учраас 2025 онд бид алдагдалгүй ажиллах гээд төлөвлөгөөгөө ТУЗ-өөрөө батлуулаад ажиллаж байгаа 2025 онд бид алдагдалгүй ажиллана гэж анх удаагаа ийм боломжууд ирсэн гэдгийг бас та бүхэндээ хэлье гэж бодож байна. Тэрнээс өмнө үнэхээр одоо үнийн ийм хатуу зохицуулалттай явж байдаг учраас яах арга байхгүй. Бид одоо энд шараар өгвөл бид нарыг үйлдвэрлэж байгаа өртөг бол нүүрс нь өртөг их гомдол. Энэ тогтоож өгсөн үнэ нь байгаа юм. Ийм явж байсан анх удаагаа бид бас ингэж бас боломжийн түвшинд үнэ очсон гэдгийг та бүхэндээ дуулгая. Мэдээж хэрэг одоо нэг жилийн дараагаар ХЭХ

болдгоороо болно бид та бүхэн тайлангаа тавьдгаараа тавина. Энэ жилийн бидний зорилт бол алдагдалгүй ажиллана гэсэн ийм зорилттой байгаа гэдгийг бас хувьцаа эзэмшигч та бүхэндээ дуулгая гэж бодож байгаа. Үнийн өөрчлөлтийн асуудал та бүхэнд бас тайлбарлачихсан ийм хариулттай байна. Ингээд ногдол ашигтай холбоотой танилцуулга боллоо. Асуух тодруулах зүйл байвал би хариулъя.

Хурлаар хэлэлцсэн нь:

4. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга Н.Жавзанпагма:

За ингээд ногдол ашигтай холбоотой мэдээллийг танилцууллаа. Дараагийн хэлэлцэх асуудлын 4-д компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай байгаа. Дүрмийн 3.1 л байгаа энэ манай та бүхэн маань компанийнхаа дүрмийг компанийн веб сайт дээр нээлттэй байгаа. Та бүхэн маань бас нэлээн харж үзсэн байх. Хоёрхон заалт дээр өөрчлөлт орж ирж байгаа юм. Компанийн дүрмийн 3.1.6 гээд. Энийг би та бүхэнд уншаад танилцуулъя. Компанийн ТУЗ-ийн одоо мөрдөгдөж байгаа дүрэм компанийн ТУЗ-ийн гишүүд гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд толгой компанийн гүйцэтгэх удирдлагаар томилолтын удирдамжийг батлуулж батлагдсан удирдамжийн дагуу ажиллана гэсэн энэ 3.1.6-гийн заалт байгаа юм. Үүнийг гишүүд гэдэг. Энэ өргөн дунд байсныгаа зөвхөн дарга гэдэг болгож л өөрчилж байгаа. Дүрмийн 3.5.1 дэх заалт энэ бас ерөнхий байсан юмыг нэлээн тодорхой болгож өгч байгаа юм. Компанийн тухай хуулийн 84.1 84.2-т заасны дагуу ТУЗ гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий инженер, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ерөнхий нягтлан бодогч компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно гээд одоогийн дүрэмд ийм заалт байна. Энд бол компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага гэсэн байсныг компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гэснийг нь болохоор газар хэлтсийн гэж тодорхой болгож өгч байгаа юм. Бүтцийн нэгж гээд ингээд ерөнхий заалт байсныг нь газар хэлтсийн удирдлага гэдэг болгож тодорхой болгож орж ирж байгаа юм. Тэгээд ийм 2 л заалтыг дүрэм дээр нэг өөрчлөлтөөр оруулж ирж байна.

Хэлэлцэх асуудлын маань дараагийн 5 дахь асуудал ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлантай танилцах. ТУЗ-ийн дарга Нямдэлгэр таныг урьж байна.

Хурлаар хэлэлцсэн нь:

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга

Шийдвэрлэсэн нь:

ТУЗ-ийн дарга Д.Нямдэлгэр:

Бүгдээрээ сайн байцгаана уу? Эрхэм Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаар товч танилцуулъя. "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2024 онд нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй буюу төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5 гишүүн, хараат бус 3 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ тодорхой асуудал эрхэлсэн хороод буюу Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаандаа бол Компанийн тухай хууль компанийн дүрмээ мөрдөж ажиллаад түрүүн Энхтүвшин захирлын танилцуулга дээр нэлээд их дэлгэрэнгүй дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн ажлуудын хувьд ТУЗ-өөс гаргах шийдвэрүүдийг өгч ажилласан байгаа. "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

нь бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ удирдлагын бодлого, үйл ажиллагааны стратегийг тодорхойлон хяналт тавих үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. тайлант хугацаанд ТУЗ нь компанийн санхүүгийн хяналт, удирдлагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын бодлогыг хэлэлцэх, сайжруулах чиглэлээр хэлэлцэн, бодлого, шийдвэрүүдийг гаргасан. Түүнчлэн 2024 онд худалдан авалтын төлөвлөгөөнд тодотгол хийх, хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой болгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Төр болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах үүрэг, чиглэл өгч, уурхайн хөрсний гулгалтын улмаас дахин ашиглах боломжгүй болсон хатаах үйлдвэрийн барилгыг буулгах асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргасан. "Шивээ-Овоо" ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц болон дүрэм журмуудаар зохицуулагдан ажилладгийн дагуу 2024 онд 90,2%-ийн үнэлгээ аваад Топ 16 компанид багтаж үнэлэгдсэн байгаа. Компанийн гол томоохон ажилтнуудаас дурдах юм бол 1. Нийт 2.63 сая тонн нүүрс олборлож, төлөвлөсөн хэмжээнээс 233.31 мянган тонноор илүү олборлосон нь компанийн техникийн хүчин чадал сайжирч, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлсний үр дүн гэж үзэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн техникийн шинэчлэлийн хүрээнд уурхайн үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр чухал ажлууд хийгдсэн. Уурхайд шинэ тоног төхөөрөмжүүд нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа сайжирч, олборлолтын хэмжээ нэмэгдэж, зардлын хэмнэлт гарсан нь үр дүнтэй байгаа гэж үзэж байна. Тэгээд компанийн 2. Борлуулалтын хувьд 2.62 сая тоннд хүрч, төлөвлөгөөнөөс 243.55 мянган тонноор давсан үзүүлэлттэй ажилласан. Түүнээс гадна байгаль орчныг хамгаалах чиглэлээр компани "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцож, 5000 хайлаас мод тарьж, усалгаа арчилгааг тогтмол хийсэн нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн томоохон ажлуудын нэг байлаа. Мөн уурхайн талбайн нөхөн сэргээлтийн ажлууд стандартын дагуу амжилттай хийгдэж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд ахиц гаргасан. Компанийн хувьд бол дотоод хяналт эрсдэлийн удирдлагын чиглэлээр 35 удаагийн хяналт шалгалт хийгдэж үүний дагуу биелэлтийг хангуулж ажиллахад анхаарч ажилласан байна. Цаашид хамтдаа тогтвортой хөгжил инновацыг дэмжсэн үйл ажиллагаагаараа зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх Монгол Улсын эрчим хүчний гол түүхий эдийг олборлож нийлүүлдэг тэргүүлэгч компани болох зорилгынхоо төлөө ингээд хичээнгүйлэн ажиллаж байгаа. Үүнийг танилцуулаад та бүхэндээ талархал илэрхийлье. Асуулт байвал хариулна.

Хувьцаа эзэмшигч:

ТУЗ-ийн гишүүд ямар хэлбэрээр хурлаа явуулдаг юм. Та нар чинь бүгдээрээ л Улаанбаатар хотод шүү дээ. Улаанбаатар хотод ажил албан тушаал эрхэлж байгаа хүмүүс байгаа. Очиж хийж байгаа юм уу?

ТУЗ-ийн дарга Д.Нямдэлгэр:

Танхимаар болон яаралтай тохиолдолд цахим хэлбэрээр хуралдаад ТУЗ-ийн үйл ажиллагаа буюу үндсэн хурлын үйл ажиллагаагаа явуулдаг байгаа. Хараат бус гишүүд очиж 2 удаа компани дээр очиж, үйлдвэрийн байдалтай танилцаж ажилласан байгаа. ТУЗ-ийн гишүүд өдөр тутмын үйл ажиллагааг удирдах шийдвэр гаргах батлах ийм түвшинд ажилладаг учраас газар дээр нь очиж хуралдаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцаж 3 удаа хурлын үйл ажиллагааг хийсэн.

Хувьцаа эзэмшигч:

Би яагаад асууж байна гэвэл та нар чинь дандаа удирдах том албан тушаалтан яамны Монгол Улсыг одоо удирдаж байгаа ийм хүнд ажилтай дээрээсээ одоо шахалт гэдэг юм уу маш өдөр тутам ийм байгаа хүмүүс чинь яаж одоо газар дээр нь очиж ийм

айхтар уул уурхайг удирддаг гэж би ойлгодог, аймаар их ажилтай мөртөө яаж ийм хурлыг ингээд хийдэг юм?

ТУЗ-ийн дарга Д.Нямдэлгэр:

Бид бол компанийн журмынхаа дагуу томилогдож ажилладаг, төлөөлөл хэрэгжүүлэхээр тэгээд тэр журмынхаа дагуу ТУЗ-ийн үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаа нь хурал учраас бид тогтоосон чиглэлийг нь баримтлаад, компанид яаралтай, тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь шийдэх гээд ажлын цагаар ч ажлын бус цагаар ч хамаагүй хуралдаад, үзээд, судлаад, хороод үзээд ажилладаг. Дээрээс нь бол бид бүрэн бүрэлдэхүүнээрээ хэсэг нөхцөлөөрөө бол очиж үйлдвэр дээр очиж танилцаад яг газар дээр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа яаж явагддаг юм ямар ямар чиглэлээр хийгдэж байгаа гэдгээр танилцсан байгаа. Тэгээд тийм байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа.

Хувьцаа эзэмшигч:

Аудитын хороонд хараат бусуудаас байгаа юу? хэдэн хүнтэй юм.

ТУЗ-ийн дарга Д.Нямдэлгэр:

Байгаа байгаа. Угаасаа компанийн хуулиар нөгөө хороодод 3-ны 2 нь хараат бус байх ёстой гэдэг зарчмаа бариад 2 хараат бус гишүүн байгаа. 3 хүнтэй, нэг нь төрийн төлөөлөл 2 нь хараат бус гэсэн үг.

Гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин:

Энэ удаагийн ТУЗ бол маш чамбай ийм чадварлаг, мэдлэг боловсрол мэргэжил өндөртэй ийм бүрэлдэхүүн байгаа. Одоо таны асуугаад байгаа хороон чинь гэхэд одоо энэ Монгол улсын тэргүүлэх аудитор санхүү эдийн засгийн чиглэлийн нэлээн өндөр боловсролтой туршлагатай ийм улсууд байгаа. Тэгээд мянга сонсохоор нэг үз гэдэг шиг газар дээр нь заримд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд очиж үзэх шаардлагатай гээд ТУЗ-ийн дарга маань шийдвэрлэлээ. Гишүүд бүгдээрээ очиж үзлээ энэ үнэхээр ийм тийм асуудал байгаа юм байна гэдгийг нөгөө очиж үзэж шийдвэрлэдэг. Тийм ч учраас та бүхэн ч гэсэн бас 1 1 удаа ч гэсэн очоод танилцаач ээ гээд уриад байгаа нь тэр. Өөр асуулттай хүн байна уу?

Хурлын дарга Н.Жавзанпагма:

ТУЗ маань 2024 оны үйл ажиллагааныхаа тайланг танилцууллаа. Та бүхэн маань асуулт хариулт авлаа. Сая танилцуулсан асуудлууд дээр та бүхэнд өгсөн саналын хуудсаа өгчихсөн байгаа тийм үү? Тэмдэглэгээгээ хийсэн үү? Тооллогын комисс маань ажилдаа ороорой. Та бүхэнд албан ёсны саналынх нь хуудаснууд тарааж байгаа шүү дээ.

Тооллогын комиссын дарга:

Аргачлалыг танилцуулж өгье. Хурлын гишүүд дээр коммулятив аргаар буюу хамгийн олон санал хураах санал цуглуулах аргаар сонгодог. Үүн дээр манай төлөөлөгчдийн гишүүд 9 хүн нэр дэвшиж байгаа. Та бүхний хувьцааг дэвшигдэж байгаа хүмүүсийн тоонд үржээд тоолдог гэсэн үг. Хөнгөлөлттэй олгох саналын тоог нэр дэвшиж байгаа хүмүүст та саналаа нэгэн нь ч өгсөн болно нэмж өгсөн ч болно хуваагаад өгсөн ч болно зүгээр заримд нь өгч саналаа өгсөн ч болно. Гол нь тэр хөнгөлөлттэй олгох ажлын тоог бас шүүх дэмжиж байх учраас таних ёстой гэсэн үг.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Хэлэлцэх асуудлын дараагийн асуудал компанийн ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох тухай. Төрийн мэдлийн хувьцаат хувьцаа эзэмшигчийг төлөөлж Л.Нямдэлгэр ЗГХЭГ, Л.Наранчимэг Эрдэнэс Монгол ХХК, Ц.Төгсбуян Эрдэнэс Монгол ХХК, П.Билгүүн Эрчим хүчний яам, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яам гээд төрийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчдийг төлөөлж ийм 6 нэр дэвшигч байна. Хараат бус

гишүүнээр С.Цолмон, П.Баянсан, Ц.Лхамсүрэн. Та бүхэн Мандахнаран даргын өгсөн зөвлөмжийн дагуу саналын хуудсаа бөглөөд саналаа өгөөрэй.

Хувьцаа эзэмшигч:

Нэр дэвшигч нартай танилцах хэрэгтэй. Сонгогчдод сонгох сонголтыг өгөх хэрэгтэй.

Нэр дэвшигч Ц.Төгсбуян:

Намайг Цэдэнбалжирын Төгсбуян гэдэг. Эрдэнэс Монгол компанийн Геологи үйлдвэрлэлийн бодлогын газрын даргаар ажилладаг. ШУТИС-ийг ашигт малтмал баяжуулалтын инженерээр төгссөн. Канадын Бритиш Колумби их сургуульд магистраа хамгаалсан. Ажиллаж байсан туршлага ОТ-н баяжуулах үйлдвэр дээр 5 жил ажиллаж байсан. Мөн Эрдэнэт үйлдвэр дээр 4 жил ажиллаж байсан ерөнхийдөө бол баяжуулагч инженер мэргэжилтэй байгаа. Эрдэнэс Монгол компанид 2 жилийн өмнө нээлттэй сонгон шалгаруулалтаар ороод ингээд 2 жил болж байна. Ажиллах хугацаандаа зэс металлын групп болон Үйлдвэр технологийн бодлогын газар дээр ажиллаад явж байна. Тэгээд ямар ч гэсэн та бүхэнтэйгээ хамт ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсондоо таатай байна.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Тооллогын комисс маань ажилдаа орчихсон байна уу? Саналаа өгөөгүй байгаа хүмүүс байвал саналаа өгөөрэй. Тооллогын комиссынхоо дүнг гартал түр завсарлая.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Хуралаа үргэлжлүүлэх үү? Тооллогын комиссын дарга маань санал хураалтын дүнгээ танилцуулна.

Тооллогын комиссын дарга:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус хүнээр сонгох санал хураалт явуулж олонхын санал авсан дараах хүмүүсийг төлөөлөх зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр батлахыг ХЭХ-д уламжилж байна. 8 дугаартай тооллогын комиссын тогтоолыг нотолж байна. Ердийн гишүүн Д.Нямдэлгэр 12078612 санал авсан. Нийт саналын хугацаагаар 11,1% болж байгаа юм байна. Дараагийн гишүүн Наранчимэг 12078185% санал авсан за хувь нь 11,1%-тай байна. Төгсбуян 12078187% санал авсан хувилах юм бол 11,1% болж байна билгүүн 12000078 172 санал авсан хувилахаар 11,1% болж байна Бүдээ 12078162 Санал санал 11,1% И.Батхүү 12078180 62 Санал 11,1% Хараат бус гишүүн Цолмон 12078162 Санал авсан 11,1% П.Баянсан 12078162 Санал авсан 11,1% Ц.Лхамсүрэн 12078162 Санал авсан 11,1% санал авсныг Комиссын 8 дугаартай тогтоолоор баталж байна. 1 дүгээр тогтоол хамгийн эхэнд танилцуулсан ирцийн хувь 90.0077%-тай гарсан байгаа. Энэ бол манай төслүүд байгаа. Бүртгэгдсэн 50-аас дээш хувь нь бүртгэлтэй учраас 1 дүгээрт тооллогын комисс бол хурал бүрэн эрхтэйг нээж байгаа юм. Дараачийн тогтоол бол 2 дугаар тогтоол компанийн үйл ажиллагааны тайлан танилцуулагдсан ирцийн хувьд бол 100% компанийн үйл ажиллагааг хангалттай гэж үнэлснийг баталгаажуулж тогтоосон байгаа. 3 дахь тогтоол ТУЗ-өөс санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийн талаар санал хураалт байгаа. Үүн дээр хувьцаа эзэмшигчид бол эсрэг санал өгөөгүй 100%-ийн санал өгсөн. Тийм учраас мөн уурхайн тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн тогтоол баталсан байгаа. 4 дүгээр тогтоол болохоор ноогдол ашиг хуваарилах асуудлаар танилцуулга хийсэн. Энэ дээр бол түрүүн хувьцаа эзэмшигчид байхгүй 100%-ийн санал. 5 дугаар тогтоол дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталсан тогтоол за үүн дээр бас 100%-ийн санал өгсөн ямар ч байсан эсрэг санал гаргаагүй учраас дүрмийн нэхэмжлэл баталсугай гэж баталсан байгаа. Хурлын өмнө бол нэг процесс ажиллагаа явагддаг байгаа. Энэ бол нөгөө өмнөх гишүүдээ чөлөөлөөд дараагийн гишүүдээ томилох ёстой. Саяын санал хураалт миний танилцуулдаг албан бичгээр ер нь гарчихсан байгаа саяын 8 дугаар тогтоол байгаа шүү. Ингээд тооллогын

комисс 8 ширхэг тогтоолын төслийг батлан тусгаж байна. Үүнийг Хувьцаа эзэмшигчид болон хурлын даргад танилцуулж байна.

Хурлаар хэлэлцсэн нь:

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Шийдвэрлэсэн нь:

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Тооллогын комисстоо баярлалаа. ХЭХ-ын тогтоолуудаа албажуулаад, нягтлаад явна. Та бүхэндээ тогтоолуудаа тус тусад нь уншиж өгөөд албажуулаад явъя. Шивээ-Овоо ХК-ийн ХЭХ-ын тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хот ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 Шивээ-овоо ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт ХЭХ-ын тооллогын комиссын 8 тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн тогтоох нь. Нэгд Шивээ-овоо ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах нэр дэвшигчдийг томилсугай 1.1.Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж 1.1.1-д Д.Нямдэлгэр 1.1.2-т Л.Наранчимэг 1.1.3-д Ц.Төгсбуян 1.1.4 П.Билгүүн 1.1.5-д Д.Бүдээ 1.1.6 И.Батхүү 1.2 Хараат бус гишүүнээр 1.2.1-д С.Цолмон 1.2.2 П.Баянсан 1.2.3 Ц.Лхамсүрэн 2-т Шивээ-овоо ХК-ийн ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг эрх бүхий байгууллагаас нэр дэвшигчдийг хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тогтоосон өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтоосугай.

2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хот компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 Шивээ-овоо ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн тогтоох нь. Нэгд Шивээ-овоо ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж сайжруулах шаардлагатай гэж баталсугай 2-т Шивээ-овоо ХК 2024 онд компанийн үйлдвэрлэлийн зорилтот түвшний биелэлтийг хангах санхүү эдийн засгийн хувьд ашигтай ажиллах, өр авлагыг багасгах, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлттэй уялдуулан, үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг ТУЗ гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай. Хурал даргалагч.

Дараагийн тогтоол Шивээ-овоо ХК-ийн ХЭХ-ын тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хот компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 Шивээ-овоо ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн тогтоох нь. Нэгд Шивээ-овоо ХК-ийн 24 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж хангалттай гэж баталсугай 2-т Шивээ-овоо ХК-ийн 2025 оны батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж компанийн үр ашгийг нэмэгд дүүлэн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг ТУЗ гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай 3-д Үндэсний Аудитын Газрын 2024 оны санхүүгийн тайланд өгсөн санал, дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд захирал удирдлагад үүрэг даалгасугай. Хурал даргалагч.

Дараагийн Тогтоол Шивээ-овоо ХК-ийн ХЭХ-ын тогтоол 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Улаанбаатар хот компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 17.9 62 дугаар зүйлийн 62.1.1 Шивээ-овоо ХК-ийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн тогтоох нь. Нэгд Шивээ-овоо ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулж баталсугай 1.1 Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д дах заалтад гишүүд гэснийг дарга гэж өөрчлөх 1.2 Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад Компанийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гэснийг газар, хэлтсийн гэж өөрчлөх, 2-т Шивээ-овоо

ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн байгууллагад хуулийн хугацаанд бүртгүүлэхийг гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшинд даалгасугай. Хурал даргалагч.

Тогтоолын төслийг бүгд дэмжив.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Ингээд тогтоолуудаа баталлаа. Ингээд манай Шивээ овоо ХК бол Монгол улсын эрчим хүчний салбар тэр дундаа төвийн эрчим хүчний төвийн бүсийн энэ эрчим хүчний системийн гол ачааллыг Нүүрс хэрэглээний гол ачааллыг бол ингээд нуруундаа үүрч явдаг. Нийгмийн хариуцлагын хүрээнд ч бас яг олборлолтын одоо өртгөөсөө доогуур үнээр энэ төв эрчим хүчний системд ингээд борлуулж явдаг бас ийм манай стратегийн чухал ач холбогдол бүхий ийм нүүрсний уурхай маань байгаа тэгээд энэ уурхайнхаа үйл ажиллагааг нь бас та бүхэн маань дэмжиж хамтран ажиллаж ингэж хувьцаа эзэмшигчийнхээ үүргийг хүлээж хамтарч ажилладаг та бүхэндээ талархаж байна. Тэгээд та бүхнийхээ цаашдын ажил амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хувьцаа эзэмшигч:

Бид нарт нэг хэдэн санал байна. Энэ хурлын дараа л хэлнэ л дээ. 1 дүгээрт бид нар яасан юм гэвэл сая нөгөө хувьцаа эзэмшигчдийг уурхайтай танилцуулж байгаа хүчин тэмцлийн стратеги нь үнэхээр ач холбогдолтой гоё том уурхай байдаг юм байна. Нийслэлийн бүх дулаан эрчим хүчийг хангаж байгаа энэ том байгууллага тэгээд тэнд ажиллаж байгаа залуучууд ихэнх нь залуучуудыг тэд нарыг цаашид тогтвортой сайн ажиллуулахын тулд энэ том стратегиа цалин нь жоохон бага юм уу гэсэн сэтгэгдэл бид нарт төрлөө. Тэр хооронд сууж байхдаа бүтэн өдөр аялсан байна. Тэгээд бид юу гэж бодсон бэ гэвэл энэ хүмүүсийн цалинг нэмэгдүүлэх арга төрийн өмчийн энэ том компани залуучууд 4 ээлжээр ажилладаг юм байна. 4 ээлжээр ажиллачихсан хүмүүс байдаг юм байна. Тэгээд нөгөөх чинь хүмүүсийн тоо нь дутуу учраас нөгөөдүүлийг чинь 3 ээлжээр ажиллуулдаг. Цалин нь бол яг үндсэн нөгөө 2 сая 400 нэмэгдэл цалин олгохгүй тэр талдаа дутагдалтай дутмаг байгаа юм уу гэсэн сэтгэгдэл төрсөн учраас бид нар энэ саналаа хэлж байна. Цалин нэмэгдэнэ гээд энэ хүмүүсийг залуучуудыг татах юм бол хотын ойролцоо байгаа юм чинь залуучууд олноороо очих тийм боломж бололцоотой газар юм. Яагаад гэвэл Улаанбаатар хотоос хоёр зуун хорьхон километр газар залуучууд гэр бүлээрээ очиж ажиллах тийм хүсэл сонирхолтой хүмүүс их байна. Ганцхан тэнд юу дутагдаад байна вэ гэхээр цалин бусад том ОТ бусад компанийг бодоход цалин арай бага юм тэгээд нэмэгдэл цалингүй тэр хүмүүстэй уулзаад ярьж явахад тийм сэтгэгдэл төрлөө. Тэгээд энэ залуучуудынхаа цалин хөлсийг нэмээд одоогийн түвшинд одоо цалин ямар байгаа юм уурхай тэр хэмжээнд хүрэх юм бол манай эрдэнэс Монгол шивээг аваад залуучууд бараг нөгөө нэг Эрдэнэт шиг Дархан шиг залуучуудын нэг уриалсан хотууд байсан шүү дээ. Бид нарын үед жараад оны үед тэрүүн шиг бараг хүмүүс бол хуйлраад очихоор тийм их гоё газар бүтээн байгуулалт сайн байна. Тэгээд залуучуудын нийгмийн асуудлыг шийдэх тал дээр маш их ажил хийдэг юм байна. Тэгээд тэр тал дээр анхаарч үзээч та эд нарыг том толгой Эрдэнэс Монголын төлөөлөгч нар сууж байгаа юм чинь энд бүүр санал оруулаад хэлье гэж бодлоо.

Хувьцаа эзэмшигч:

За би ч гэсэн нэг юм хэлээдэхье. Шивээ-овоо чинь бол энэ төрийн өмчит тэгээд нийтдээ 200 сая жилийн насжилттай гэж байна шүү дээ. Өшөө нөөцтэй гэж байна шүү дээ тийм үү? Тэгвэл энэ нөөцөд чинь дандаа монголчууд ажиллаж байна. Монголчууд ажиллаж байгаа юм чинь монголчуудынхаа улам сайн дэмжээд бусад компаниудынхаа жишигт гадаадад заавал ч үгүй хөрөнгө оруулагчтайгаа энэ зэрэгцээд явахад яадаг юм болдоггүй юм уу? Тэртээ тэргүй юу гэдэг хамгийн гол нь болохлоороо энэ улсууд одоо ингээд явж байна шүү дээ. Одоо манай хүүхэд хүртэл Шивээ-овоод ажиллаж байсан яг тийм Шивээ-овоод амьдарч байсан тэгээд ээж

үнэндээ цалин багатай юм аа лизингээ төлж чадахгүй байна тэгээд хүүхдээ сургуулийн төлбөр гэж тэгээд ОТ руу шилжихье тэгээд манай хүүхдүүд чинь ОТ руу шилжлээ. Тэгээд үнэндээ болох дээр зэрэг яах вэ амьдрах нөхцөл нь гэх дээр чинь байр орон сууц бас хамгийн түрүүнд хэрэгтэй. Залуучууд тэгээд нөгөөдүүл чинь лизингээ төлж чадахгүй яг авсан цалин чинь 200 2 сая 400 мянга тэгээд энэ чинь ингээд ээлжээр ажиллах гэх дээр 4 ээлжээр ажиллах юм болбол бас нөгөө хүүхдүүддээ зарцуулах цаг өөрийгөө хөгжүүлэх цаг нь илүү гарна тийм үү. Тэгэхэд чинь энд нөгөө хүн өгч байхгүй болох дээр 3 ээлжээр яваад байдаг 3 ээлжээр яваад байх дээр цалингийн задаргааг харах дээр зэрэг аягүй өндөр цалинтай юм шиг гарч ирээд байдаг байхгүй юу 4 сая 5 сая гээд тэгсэн хэр нь нөгөө улсууд чинь уурхай чинь ямар билээ хүний биед ямар билээ дээ энэ чинь. Гадаа гарч хөлдөж хүйтэнд халаад халуунд халууцаад явж байгаа нөхцөлд ажиллаж байгаа улсууд чинь 4 ээлжээрээ ажиллах юм болбол яадаг юм. Эрүүл мэнд тэгээд хүүхдүүд дээ зарцуулах цаг байна өөрийгөө хөгжүүлэх цаг гарна. Тэгэхдээ 3 өдөр ингээд явахад яах вэ. Цалин өндөр авч байгаа боловч өөрсдөд нь залуучуудад өөрсдөд нь бас нөгөө өсөн дэвжих цаг нь аягүй хомс байдаг байхгүй юу. Тийм учраас энэ хүүхдүүдийг татахын тулд одоо яаж байна? Үгүй ээ энэ дээр дадлага хийж байгаа хүүхдүүд аягүй их байгаа байхгүй юу. ШУТИС-аас манай хүүхдүүд ч гэсэн бол уурхайн юуны юу билээ, ашиглалтын инженер, одоо өөрөө нөгөө юу билээ, үйл уурхайн нөгөө бас нөгөө аягүй олон техник хариуцаад ингээд ажилладаг ажилладаг тийм хүүхдүүд байсан байхгүй юу. Тэгээд одоо яг 5 6 хүүхдээр бүгд ингээд ОТ руу явчихсан юм. Тэгээд яг өөрийнхөө монголчуудаа хариуцаж байгаа монголчуудтайгаа ажиллаж байгаа энэ залуучуудыг ЗГ тэртээ тэргүй та нар төлөөлөөд сууж байгаа юм чинь өшөө цааш нь та нар хүчтэйхэн шиг эд нартайгаа улам их сайхан анхаарал тавьж өгөөсэй л гэж хүсэж байна.

Хурлын дарга Н.Жавзанпагма:

Та бүхэн ёстой үнэтэй санал өгч байна. Цахилгаан дулааны үнийг бас барихын тулд гол түүхий эд болох нүүрсний үнийг олборлолтынх нь өртгөөс доогуур үнээр манай энэ систем авдаг тэгээд энэ чинь ганц Шивээ-овоо Багануур 2 маань л нүүрсээ нийлүүлдэг тэгээд олборлолтын өртгөөсөө доогуур нийлүүлж байгаа энэ 2 компанийн маань ашигт ажиллагаа гэдэг чинь ямар түвшинд байгааг сая Энхтүвшин захирлын тайлан дээр гарч байна. Тэгээд саяын 12 сард үнэ индексжүүлээд өртгийнх нь түвшинд үнийг аваачлаа гээд бас та бүхэнд маань танилцууллаа. Тэгэхээр энэ жилээс эхлээд ашиг алдагдлын түвшин балансжиж ашигт ажиллагаа руугаа орж ирэх байх гэж найдаж байгаа. Тийм болохоор ТУЗ Нямдэлгэр дарга Төгсбуян дарга болон Энхтүвшин захиралд уурхайн ажилтан албан хаагч, мэргэжилтнүүдийнхээ цалин урамшуулал нийгмийн халамж анхаарал хандуулахыг та бүхнээс хүсэж, хурлаасаа ингэж чиглэл өгье. Баярлалаа.

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдэж байна.

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 13 цаг 15 минутад дуусав

ХУРЛЫН ДАРГА



Н.ЖАВЗАНПАГМА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.СОЛОНГО